

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖИЙН
02 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ**

2020 оны 02 дугаар сарын 28

Багануур дүүрэг

№	Ирсэн огноо	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт
1	2019.06.28	2019.06.21	A/619	Паркийн "Үйлдвэрийн албан контор"-ын барилгын зураг төслийг гүйцэтгэгч Нутаг Консалт ХХК-д холбогдох бичиг баримтуудыг гарган, хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авч, гадна шугам сүлжээний холболтын цэгийг заалган ажлын зургийг гүйцэтгэж байна.
2	2019.06.28	2019.06.21	A/619	"Санни трейд" ХХК-ийн гүйцэтгэсэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг парк 02 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан.
3	2019.10.11	2019.10.09	A/1054	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-т 2020 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар нийт 18 бичиг ирснээс хариутай бичиг 5, хариугүй бичиг 13, хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар яам, нийслэл, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 10 албан бичиг явуулсан байна.
4	2020.01.28	2020.01.27	A/108	1.6 дугаар заалтын дагуу Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн /санитол/ гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр тогтмол ариутгаж байна. Мөн ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан мэдээллийг baganuur-itp.mn цахим хуудсанд тогтмол байршуулж байна. Захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн пүрэв гаригт Zendmaal@gmail.com цахим хаягт илгээн тайлагнаж байна.
5	2020.02.07	2020.02.07	A/168	Уг захирамжийг албан хаагчдад танилцуулан, Шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх уриалгыг гарган байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Мөн орчны 50 м хүртэлх газрын цас, мөс, хог хаягдлыг цэвэрлэн ажиллаж байна. Захирамжийн эхний биелэлтийг НЗДТГ-ын ХШ, ҮХ-т 02 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлэн тайлагнасан.

6	2020.02.14	2020.02.13	A/191	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шинэ корона вирустэй холбоотойгоор нэмэлт заалт тодотгол оруулан албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тус тус байршуулсан.
---	------------	------------	-------	--

ХЯНАСАН:
 “БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *CS* Ч.ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Laxwit* Б.НОМИНЗУЛ